



СОЁМБО МЭДЭЭ

“СОЁМБО” РЕДАКЦААС ЭРХЛЭН ГАРГАДАГ ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2021.04.27 №40 (40)

ҮЙЛ ЯВДАЛ

“ЦЭРГИЙН ХҮЧИЙГ ТЭНЦВЭРЖҮҮЛЭХ НЬ” СЭДЭВТ ДАДЛАГА ЯВУУЛЛАА



БНӨСУ-д явагдаж буй НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэж буй цэргийн хүчний тоог багасгахаар төлөвлөж

байгаатай холбогдуулан Жуба бүсийн командлал болон Өмнөд бүсийн командлалын цэргийн хүчийг шилжүүлэн нэгтгэхээр төлөвлөөд байгаа билээ. Үүнтэй холбоотойгоор Жуба бүсийн командлагч, хурандаа Б.Эрдэнэбат тэргүүтэй штабын удирдлага өөрийн бүсийн харьяалалд ирэх цэргийн багууд буюу штабын офицер, цэргийн багийн захирагч, ажиллагааны ахлах офицеруудтай “Цэргийн хүчийг тэнцвэржүүлэх нь” сэдвээр штабын хэсэгчилсэн дадлагыг амжилттай зохион явууллаа.

Мөн хурандаа Б.Эрдэнэбат Жуба бүсийн хариуцлагын бүсэд хамаарах “Мангалла” суурингийн усан боомтод Бангладеш Улсын усан цэргийн багаас томилогдсон бүрэлдэхүүн түр хуаран байгуулан ажиллаж байгаатай танилцаж, цаашид “Малакал” муж руу усан замаар хангалтын шатахуун, материал хэрэгсэл тээвэрлэх бэлтгэл ажлын явцыг үзэж сонирхсон юм.

Хошууч Н.ГАНТУЛГА

ТОМИЛГООТ БҮРЭЛДЭХҮҮН ОРОН НУТГИЙН ПОСТУУДАД ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЖ БАЙНА



Цар тахлын халдварын тархалтыг хумих зорилгоор улс орон даяар бүх нийтийн бэлэн байдлын зэвсэгт хүчний алба хаагчид цагдаа, онцгой байдлын байгууллагын алба хаагчдад дэмжлэг үзүүлэн ажиллаж байна.

Тухайлбал, холбогдох тогтоол, албан даалгавар, шийдвэрээр, Аймгийн Онцгой комиссын штабаас

ирүүлсэн албан хүсэлтийг үндэслэн Баянхонгор, Дархан-Уул, Дорнод, Дундговь, Завхан, Сүхбаатар, Өвөрхангай, Өмнөговь, Ховд, Хөвсгөл аймагт Зэвсэгт хүчний 123, 167, 256, 330, 325, 327, 338, 339 болон 065, 325 дугаар ангийн тусгай салбаруудын 250 гаруй цэргийн алба хаагч иргэдийн хөдөлгөөнд хяналт тавьж, Засгийн газар, УОК-ын шийдвэрийг мөрдүүлж байгаа юм.

Баярлалаа Монгол



Саяхан Өмнөд Судан Улсын Жам Жанг суурингийн ойролцоо НҮБ-ын хүмүүнлэгийн ажилчид руу 50 орчим зэвсэгтэй хүмүүс дайралт хийх үед #UNMISS Монголын түргэн байрлах хүчний дайчид хэргийн газарт даруй очиж:

- ажилчдыг хамгаалж
- хүчирхийлэл даамжирхаас сэргийлж шархдсан хүмүүст эмнэлгийн

тусламж үзүүлжээ. Thank you Mongolia! Өмнөд Суданы иргэд Монгол Улсад талархаж байна хэмээн НҮБ-ын цахим хуудсанд бичжээ. БНӨСУ-д Монгол Улсын Зэвсэгт хүчний 10 дугаар ээлжийн МББ үүрэг гүйцэтгэж байгаа бөгөөд тэд дэлхийн өмнө хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж байгаагийн нэг жишээ нь энэ юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 3	☁️ -5

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 34	☁️ 23

АФГАНИСТАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 26	☁️ 12

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	2.845.00	2.856.00
EUR 🇪🇺	3.419.00	3.478.00
CNY 🇨🇳	437.50	441.20
RUB 🇷🇺	37.50	39.10
JPY 🇯🇵	26.13	26.63
KRW 🇰🇷	2.47	2.60

ӨРНИЙН ЗУРХАЙ

БИЛГИЙН ТООЛЛЫН 15
2021.04.27.
/МЯГМАР ГАРАГ/

**ХАВРЫН АДАГ ХАР ЛУУ
САРЫН НАЙМАН ЦАГААН
ХӨХӨГЧИН МОГОЙ ӨДӨР**

Үс засуулбал:

Өлзийтэй сайн.

Наран ургах, шингээ:

05.41-19.59

Барилдлага:

Хүчин төгсөх

Шүтэн барилдлага:

Хурьцахуй

Суудал:

Уул.

Аргын тооллын 4 дүгээр сарын 27, Ангараг гараг. Билгийн тооллын 15, Салхины эх одтой, хөхөгчин могой өдөр. Өдрийн наран 5 цаг 41 минутад мандан, 19 цаг 59 минутад жаргана. Тухайн өдөр үхэр жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлийг эхлэх, дээдсээс халамж хүсэх, лам хувраг болох, багш шавьд барилдах, номын авшиг авах, шинэ гэр ба байр авах, сан тавуулах, угаал үйлдэх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, гэр бүрэхэд сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, сэтгэлд сэтгэй газар очиход муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одоосод баруун хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал өлзийтэй сайн.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН

30.483+856

ЭДГЭРСЭН

16.815

НАС БАРСАН

80/8

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН

1919 (20)

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ

299

ЭДГЭРСЭН

1600

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 146,054,107

Эдгэрсэн

Нийт: 119,064,309

Нас барсан

Нийт: 3,092,410

МУ-ын хэмжээнд 04 дүгээр сарын 26-ны өдрийн байдлаар нийт 707838 (33.7%) иргэн КОВИД-19 эсрэг вакцины эхний тунд, 2-р тунд 239971 (11.4%) иргэн хамрагдлаа.

Нийслэлд нийт Эхний тунд 557386 (48.0%) 2-р тунд 232601 (20.0%)

Орон нутагт нийт эхний тунд 150452 2-р тунд 7370

ЦАХИМ ШУУДАНД

ИРГЭДЭД ХҮРСЭН ОЛОН БҮТЭЭЛЧ АЖЛЫГ ӨРНҮҮЛЖ БАЙНА



Багануур дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Багануур дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб хөл хорионы үед биеэр дүйцүүлэх албан хаагчид, дүүргийн Цагдаагийн хэлтсийн алба хаагчидтай хамтран 4 дүгээр сарын 12-ны өдрөөс эхлэн өглөө 7-15, орой 15-23 цагийн хооронд 2 ээлжээр эргүүлийн үүрэг гүйцэтгэж, ард иргэдэд УОК-ын шийдвэрийг танилцуулан хэрэгжилтийг хангуулах, халдвар хамгааллын дэглэмийг сахин биелүүлэхийг зөвлөн ажиллаж байна. Цэргийн штабаас эргүүлийн үүрэг гүйцэтгэж байгаа биеэр дүйцүүлэх албан хаагчдын эрүүл мэндийн байдал, халдвар хамгааллын дэглэм хэрхэн сахиж байгаад өдөр бүр хяналт тавин, хамгаалах хэрэгсэл, халуун хоол цай, амин дэмээр хангаж, нийт 21 алба хаагчийг дархлаажуулалтын вакцины эхний тунд хамрууллаа.

Мөн БХЯ, нийслэлийн ЗДТГ-

ын Цэргийн штабаас өгсөн үүргийн дагуу орон нутагт байрлах төрийн цэргийн байгууллагын харилцан ажиллагааг идэвхжүүлэх, хамтран ажиллах хүрээнд Хилийн цэргийн 0252 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагчдад цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор нэг удаагийн амны хаалт 1000 ширхэг, хамгаалалтын хувцас 15 ширхэг, гар ариутгагч 30 ширхэг, С, Д амин дэм тус бүр 3 хайрцгийг өглөө.

Батлан хамгаалах хууль тогтоомж, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах ажлын хүрээнд Үндсэн хуульд заасан иргэний үүргээ нэр төртэй биелүүлж, гурван хүүхдээ хугацаат цэргийн алба хаалгасан өрхийн судалгааг гарган 4 эцэг эх, цэргийн алба хаасан 1 иргэнийг ярилцлагад урьж, хүүхэд залуусыг цэргийн алба хаахыг уриалсан шторк бэлтгэн дүүргийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан ард иргэдэд хүргэлээ. Түүнчлэн ЗГХЭГ-ын Хяналт-

шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас зохион байгуулсан “Үр дүнд суурилсан бодлого, төлөвлөлт, хяналт-шинжилгээ, үнэлгээ”, нийслэлийн Сургалт судалгааны төвөөс зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн манлайлал”, “Төрийн албан хаагчийн ёс зүй”, “Архив, албан хэрэг хөтлөлт”, нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штаб, “Идэр” их сургуультай хамтран зохион байгуулсан “Монгол бичиг”-ийн анхан болон дунд шатны цахим сургалтад бие бүрэлдэхүүнийг хамруулж гэрчилгээжүүлэв. Мөн штабын бие бүрэлдэхүүнийг цэргийн алба хаагчийн бие бялдрын шалгуур үзүүлэлт, биеийн жингийн зохистой харьцааг хангуулах, спортоор дархлаагаа дэмжих зорилгоор өглөө бүр гүйлт, дасгал хөдөлгөөн хийлгэж нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын офицер, ахлагч нарыг “Цахимаар гүйцгээе” чөлленжид нэгдэхийг уриалаад байна.

ӨМНИЙН ГОВИЙН ДАЙЧИД АВАРГУУДАА ТОДРУУЛЛАА

Зэвсэгт хүчний 167 дугаар анги

Ангийн мэдээлэл сурталчилгаа, соёл хүмүүжлийн албанаас хугацаат цэргийн алба хаагчдын дунд Тасгийн марш тактикийн аварга шалгаруулах тэмцээнийг Сургалтын нэгдсэн төвийг түшиглэн амжилттай явууллаа.

Хугацаат албаны дайчдын мэргэжлийн ур чадвар, бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлийг сорьж, эр зориг, авхаалж самбаа, тэсвэр хатуужил олгох, тасаг, салааны жигдрэлтийг хангах зорилготой энэхүү тэмцээний тэргүүн байрт дэд түрүүч Х.Лхамсүрэн захирагчтай тасаг, дэд байрт дэд түрүүч Ө.Цэдэнсодном захирагчтай тасаг, гутгаар байрт ахлах байлдагч Г.Лувсанцэрэн захирагчтай тасаг тус тус шалгарч, бусдыгаа манлайлсан юм.

Тэмцээн гарааны өмнөх



ажиллагаа, 10 км-ийн марш үйлдэх, гардан тулаан гэсэн хэд хэдэн сэдвийн хүрээнд явагдсан бөгөөд тэмцээний ерөнхий шүүгчээр ангийн Захирагчийн орлогч, захиргааны

удирдлагын тасгийн дарга, хошууч Ж.Үүрцайх, шүүгчээр ахлах дэслэгч Б.Болд-Эрдэнэ, ахлах дэслэгч Ү.Жанчивдорж нар ажилласан юм.

Ахмад Ё.БАТ-ЭРДЭНЭ



ЗАМ ХАРГУЙ НЭЭХ АЖИЛД



Энэ сарын 24, 25-нд орсон их хэмжээний хур тунадас, цасан шуурганы улмаас хангайн сумдад зам даваа хаагдах, зарим газраа мөсөн бүрхүүл тогтох зэрэг цаг агаарын бэрхшээл бий болоод байна.

Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан Онцгой комиссын цаг агаарын аюулт үзэгдлийн үед ажиллах шуурхай ажлын хэсгээс Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн алба хаагчдыг Галуут сумаас зүүн хойд зүгт 80 орчим км газарт цас,

мөсөн хунгарт боогдсон 100 орчим өрхийн 300 гаруй малчдад зам харгуй гаргах, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, өвс тэжээл хүргүүлэхээр томиллоо.

Малчдад туслах ажлын хэсэг 6 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй, хоёр нэгж техник хэрэгсэлтэйгээр өнгөрсөн Ням гарагийн 23:20 цагт Баянхонгор сумаас хөдөлсөн байна. Баянхонгор аймгийн Засаг дарга Д.Мөнхсайхан ЗХЖШ-аас холбогдох зөвшөөрлийг авснаар уг зохицуулалтыг хийсэн аж.

ЦАГ ҮЕ

16 АЙМАГТ ХҮЧИЛТӨРӨГЧИЙН БЭСРЭГ ҮЙЛДВЭР БАЙГУУЛНА

Эрүүл мэндийн яамны удирдлагууд өчигдөр аймгуудын Засаг дарга нартай халдварын нөхцөл байдлын талаар цахим уулзалт хийлээ. Энэ үеэр Эрүүл мэндийн сайд С.Энхболд орон нутгийн эмнэлгүүдэд шаардлагатай худалдан авалтыг хийж байгаа талаар мэдээлэв. Тухайлбал, Архангай, Булган аймгийн Нэгдсэн эмнэлэг, Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд нийт 4.2 тэрбум төгрөгөөр гурван ширхэг компьютер, томографын аппарат авсан байна. Мөн 9.3 тэрбум төгрөгийн үнэтэй, хүчилтөрөгчийн

бэсрэг үйлдвэрийг 16 аймагт хоёр сарын дотор барих аж. Сонгон шалгаруулалтад шалгарсан компани тоног төхөөрөмжүүдээ захиалсан. Түүнчлэн бөөрний дутагдалтай иргэд манай улсад цөөнгүй байдаг бөгөөд гемодиализын аппаратыг 14 аймагт хуваарилах ажээ.

Эмч нар хаа сайгүй дутагдалтай байгаа ба ялангуяа тархвар судлаач, лабораторийн эмч, лаборант нар ихээхэн дутагдалтай байгааг үндэслэн богино хугацааны сургалтууд зохион байгуулах гэж байгаа талаар мэдээлэл өглөө.

ДАРХЛААЖУУЛАЛТЫН 160 ЦЭГ АЖИЛЛАЖ БАЙНА



“Ковид-19” халдварын нөхцөл байдалтай холбогдуулан Засгийн газраас хатуу хөл хорионы хугацаанд хүн амыг дархлаажуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх чиглэл өгсөн.

Энэ дагуу Нийслэлийн Эрүүл мэндийн газраас энэ сарын 23-наас эхлэн нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа дархлаажуулалтын суурин цэгийн

тоог 120 болгон нэмэгдүүлж, дархлаажуулалт хийх зориулалтаар тохижуулсан том оврын 40 автобусыг түр цэг болгон үйл ажиллагаагаа өргөжүүлээд байна. Мөн Нийслэлийн Эрүүл мэндийн газраас дархлаажуулалтын суурин болон явуулын цэгт хийх дэмжлэгт хяналтыг эрчимжүүлэн, мэргэжил арга зүйгээр ханган ажиллаж байгаа юм.